



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Дарви сумын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/174/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас:70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Н.Батзул Утас:70432545 Цахим хаяг: batzul.n@audit.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Зөвлөмж	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 127
танай 2026.01.23 -ны № 12 -т

ДАРВИ СУМЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАНДИНЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дарви сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн нийт зардлын дүн өмнөх оноос 386.8 сая төгрөгөөр өссөн нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал тус тус өссөн нь нөлөөлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Улсын тэргүүний Дарви сум нь 2025 оны ажлын үзүүлэлт, үр дүнгээр Ховд аймгийн 17 сумаас шилдэг сумаар шалгарсан бөгөөд үүнд тухайн сумын бүх төрийн байгууллагуудын үйл ажиллагаа түүний үр дүн нөлөөлсөн.

8426050391

Дарви сумын сургуулийн ахлах болон дунд ангийн сурагчдын үдийн хоолонд 87.2 сая төгрөгийг МОЭНКО ХХК-ны Орон нутгийг дэмжих санхүүжилтээс ОНХС-р дамжуулан зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



ХСӨЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>246,014,489.39</u>	<u>187,546,129.65</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	88,828,792.39	28,156,240.89
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	88,828,792.39	28,156,240.89
3121	Төгрөг	88,828,792.39	28,156,240.89
31211	Төрийн сангийн харилцах	88,828,792.39	28,156,240.89
33	АВЛАГА	-	2,751,155.76
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,751,155.76
35	БАРАА МАТЕРИАЛ	157,185,697.00	156,638,733.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	108,800.00	2,123,150.00
354	Хангамжийн материал	155,888,897.00	153,327,583.00
35410	Бичиг хэргийн материал	603,000.00	574,500.00
35420	Аж ахуйн материал	1,550,951.00	1,999,602.00
35460	Хүнсний материал	8,172,760.00	3,701,670.00
35470	Бусад хангамжийн материал	145,562,186.00	147,051,811.00
35600	Мал амьтад	1,188,000.00	1,188,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,130,343,449.49</u>	<u>3,160,239,601.31</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,130,343,449.49	3,160,239,601.31
392	Биет хөрөнгө	3,048,041,449.33	3,078,187,601.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,678,278,983.00	2,752,586,202.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(361,329,393.42)	(430,107,809.58)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	669,356,891.04	799,531,171.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(275,944,878.31)	(364,656,122.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	281,962,132.00	311,075,054.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(116,382,894.66)	(148,412,611.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	189,204,962.85	189,204,962.85
39215	Хуримтлагдсан элэгдэл	(61,907,098.49)	(75,835,990.49)
39217	Ном	44,802,745.32	44,802,745.32
393	Биет бус хөрөнгө	82,302,000.16	82,052,000.20
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(999,999.84)	(1,249,999.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	82,052,000.00	82,052,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,376,357,938.88</u>	<u>3,347,785,730.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>80,625,750.00</u>	<u>62,348,500.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	80,625,750.00	62,348,500.00
413	Өглөг	80,625,750.00	62,348,500.00
4136	Бусад өглөг	80,625,750.00	62,348,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	77,775,750.00	59,498,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,850,000.00	2,850,000.00
51	Засгийн газрын хувь оролцоо	3,295,732,188.88	3,285,437,230.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,103,560,457.54	1,103,560,457.54
51101	Өмч: - төрийн	1,103,560,457.54	1,103,560,457.54
512	Хуримтлагдсан үр дүн	723,475,640.13	713,180,682.21
51210	Өмнөх үеийн үр дүн	723,475,640.13	723,475,640.13
51220	Тайлант үеийн үр дүн	-	(10,294,957.92)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,468,696,091.21	1,468,696,091.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,376,357,938.88</u>	<u>3,347,785,730.96</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,260,668,828.00	3,230,132,546.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	593,739,128.00	239,425,146.00
120	Нийтлэг татварын бус орлого	593,739,128.00	239,425,146.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	593,739,128.00	239,425,146.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,704,400.00	725,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,862,800.00	9,535,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	563,171,928.00	229,165,146.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,666,929,700.00	2,990,707,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,420,918,300.00	2,730,622,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,420,918,300.00	2,730,622,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	246,011,400.00	260,084,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	246,011,400.00	260,084,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,742,027,453.81	3,240,427,503.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,742,027,453.81	3,240,427,503.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,644,772,013.81	3,156,659,768.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,832,443,788.10	2,227,085,757.29
210101	Үндсэн цалин	1,042,374,817.10	1,259,692,962.29
210102	Нэмэгдэл	686,503,753.00	854,889,005.00
210104	Урамшуулал	103,565,218.00	112,503,790.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	228,004,897.87	280,356,682.95
210201	Тэтгэврийн даатгал	155,797,991.60	189,560,397.04
210202	Тэтгэмжийн даатгал	18,321,597.10	22,480,253.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,160,799.87	12,679,528.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,944,898.33	11,219,072.74
210205	Эрүүл мэндийн даатгал	35,779,610.97	44,417,431.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	243,637,650.00	249,207,100.00
210301	Гэрэл, цахилгаан	15,173,141.98	36,863,338.90
210302	Түлш, халаалт	228,464,508.02	209,523,761.10
210303	Цэвэр, бохир ус	-	2,820,000.00
2105	Нормативт зардал	87,758,580.00	86,273,390.00
210502	Хоол, хүнс	87,758,580.00	86,273,390.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,400,000.00	10,035,200.00
210604	Урсгал засвар	2,400,000.00	10,035,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,616,548.61	31,722,032.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,644,600.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,971,948.61	31,722,032.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	209,910,549.23	271,979,605.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,861,300.00	51,867,227.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,323,938.00	16,414,109.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	136,725,311.23	203,698,269.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,255,440.00	83,767,735.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,255,440.00	83,767,735.61
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,296,140.00	83,767,735.61
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,959,300.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	518,641,374.19	(10,294,957.92)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	518,641,374.19	(10,294,957.92)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,103,560,457.54	1,468,696,091.21	204,834,265.94	2,777,090,814.69
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,103,560,457.54	1,468,696,091.21	204,834,265.94	2,777,090,814.69
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	518,641,374.19	518,641,374.19
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,103,560,457.54	1,468,696,091.21	723,475,640.13	3,295,732,188.88
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,103,560,457.54	1,468,696,091.21	723,475,640.13	3,295,732,188.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,103,560,457.54	1,468,696,091.21	723,475,640.13	3,295,732,188.88
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(10,294,957.92)	(10,294,957.92)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,103,560,457.54	1,468,696,091.21	713,180,682.21	3,285,437,230.96

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,697,496,900.00	3,000,967,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,567,200.00	10,260,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	30,567,200.00	10,260,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,567,200.00	10,260,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,704,400.00	725,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,862,800.00	9,535,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,666,929,700.00	2,990,707,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,420,918,300.00	2,730,622,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,420,918,300.00	2,730,622,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	246,011,400.00	260,084,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	246,011,400.00	260,084,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,674,814,016.61	3,061,639,951.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,674,814,016.61	3,061,639,951.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,587,018,478.61	2,981,939,764.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,831,253,485.00	2,231,532,396.00
210101	Үндсэн цалин	980,929,031.00	1,185,552,694.00
210102	Нэмэгдэл	696,591,634.00	880,505,485.00
210104	Урамшуулал	153,732,820.00	165,474,217.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	229,162,994.00	278,661,200.00
210201	Тэтгэврийн даатгал	163,705,094.00	191,369,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,191,600.00	20,412,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,595,700.00	11,146,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,534,100.00	11,146,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,136,500.00	44,585,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	243,611,400.00	251,284,600.00
210301	Гэрэл, цахилгаан	15,173,141.98	38,940,838.90

210302	Түлш, халаалт	228,438,258.02	209,523,761.10
210303	Цэвэр, бохир ус	-	2,820,000.00
2105	Нормативт зардал	77,239,700.00	81,802,300.00
210502	Хоол, хүнс	77,239,700.00	81,802,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,400,000.00	8,089,400.00
210604	Урсгал засвар	2,400,000.00	8,089,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,317,199.61	31,815,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,645,600.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,671,599.61	31,815,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,033,700.00	98,754,468.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	142,657,980.00	87,250,568.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,375,720.00	11,503,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,795,538.00	79,700,186.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,795,538.00	79,700,186.61
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,836,238.00	79,700,186.61
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,959,300.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	22,682,883.39	(60,672,551.50)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,682,883.39	(60,672,551.50)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	66,145,909.00	88,828,792.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	88,828,792.39	28,156,240.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,120,569,700.00	3,061,639,951.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,120,569,700.00	3,061,639,951.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,027,377,700.00	2,981,939,764.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,273,174,800.00	2,231,532,396.00
210101	Үндсэн цалин	1,375,306,200.00	1,185,552,694.00
210102	Нэмэгдэл	823,552,000.00	880,505,485.00
210104	Урамшуулал	74,316,600.00	165,474,217.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	284,146,800.00	278,661,200.00
210201	Тэтгэврийн даатгал	193,219,800.00	191,369,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	22,731,700.00	20,412,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,365,900.00	11,146,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	11,365,900.00	11,146,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,463,500.00	44,585,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	251,284,600.00	251,284,600.00
210301	Гэрэл, цахилгаан	19,605,500.00	38,940,838.90
210302	Түлш, халаалт	228,859,100.00	209,523,761.10
210303	Цэвэр, бохир ус	2,820,000.00	2,820,000.00
2105	Нормативт зардал	81,802,300.00	81,802,300.00
210502	Хоол, хүнс	81,802,300.00	81,802,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,800,000.00	8,089,400.00
210604	Урсгал засвар	8,800,000.00	8,089,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,272,000.00	31,815,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	725,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,547,000.00	31,815,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,897,200.00	98,754,468.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,048,300.00	87,250,568.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,848,900.00	11,503,900.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,192,000.00	79,700,186.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,192,000.00	79,700,186.61
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	93,192,000.00	79,700,186.61
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,120,569,700.00	3,000,967,400.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,761,396,600.00	2,730,622,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,761,396,600.00	2,730,622,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	260,084,600.00	260,084,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	260,084,600.00	260,084,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	99,088,500.00	10,260,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	725,000.00	725,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,535,000.00	9,535,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	88,828,500.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		88,828,792.39
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		28,156,240.89
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	70	69
620001	Удирдах ажилтан	4	4
620002	Гүйцэтгэх ажилтан	40	39
620003	Үйлчлэх ажилтан	26	26

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,188.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, залруулагдаагүй 1,188.0 мянган төгрөгийн зөрчилд 1,188.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 1,188.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнийг хэтрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Хөрөнгөтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Бараа материалын мал амьтан хэсэгт бүртгэлтэй 1,188,000.0 төгрөгийн хөрөнгийн тооллого, тооцоо хийж нас дэвшил тооцоогүй байгаа нь НББ-н тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д " Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Малыг газар дээр нь очиж тоолж баталгаажуулж үр дүнг тайлагнах.

3.1.2 Хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 26 мэдээлэл хоцорсон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 9-р сараас бусад саруудад санхүүжилт мэдээлээгүй, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, дараа жилийн төсөв, аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг мэдээллүүдийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1-д заасан зарчмууд, 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн дагуу мэдээлэл мэдээллийг заасан хугацаанд, бүрэн гүйцэт, үнэн зөв мэдээлж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Хуулнау байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Мал амьтан тооллого хийгээгүй, нас дэвшил тооцоогүй	1	1,188.0	1	1,188.0						
2	Ахлах дунд ангийн сурагчдын үдийн хоолны санхүүжилтийг өөрийн байгууллагын дансаар дамжуулж бүртгэж, тайлагнаагүй.	1	0	1	0						
	Нийт дүн	1	1,188.0	2	1,188.0						

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9
Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг бүрэн үнэн зөв мэдээлээгүй	1	0				0	1	-
ДҮН	1	0				0	1	0

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			